



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/18/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261885 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 261885 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Урьдчилгаа	10
3.5.3 Бараа материал	10
3.5.4 Үндсэн хөрөнгө	11
3.5.5 Өр төлбөр	11
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	14
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Харьяа байгууллагууд	15
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	15
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	15
4.2.2.Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ЗГ	Засгийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР
ТАНАА

2022.03.25 № 01/409
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,538,187.8	1,332,136.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	42,942.4	34,177.7
34	УРЬДЧИЛГАА	9,225.1	2,480.3
35	БАРАА МАТЕРИАЛ	1,486,020.2	1,295,478.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,655,134.3	8,721,431.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,655,134.3	8,721,431.2
39200	Биет хөрөнгө	8,103,182.6	8,080,781.5
39300	Биет бус хөрөнгө	551,951.7	640,649.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,193,322.1	10,053,567.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,094.4	7,997.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,094.4	7,997.1
41300	Өглөг	0.0	7,997.1
41400	Урьдчилж орсон орлого	4,094.4	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,189,227.7	10,045,570.7
51	Засгийн газрын хувь оролцоо	10,189,227.7	10,045,570.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,433,292.5	1,433,292.5
51200	Хуримтлагдсан үр дүн	6,411,363.5	6,267,706.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,344,571.7	2,344,571.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,193,322.1	10,053,567.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,485,413.8	7,711,553.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,106,646.2	893,782.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,106,646.2	893,782.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,378,767.6	6,817,771.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,277,017.8	7,848,893.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,277,017.8	7,848,893.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,848,240.2	7,177,670.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,853,256.4	4,068,776.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	484,670.7	516,940.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	241,641.6	238,898.2
2104	Хангамж, бараа материалын зардал	551,076.8	580,974.7
2105	Норматив зардал	13,791.8	17,480.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,245.4	310,663.9
2107	Томилолт, зочны зардал	30,205.6	27,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	328,001.6	328,947.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,238,350.4	1,087,288.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,428,777.6	671,223.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	208,396.0	(137,339.9)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,540.4	6,317.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	168,855.6	(143,657.0)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,022,559.7	10,022,559.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,187.7)	(2,187.7)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,020,372.0	10,020,372.0
9	Тайлант үеийн үр дүн	168,855.6	168,855.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,189,227.7	10,189,227.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,189,227.7	10,189,227.7
19	Тайлант үеийн үр дүн	(143,657.0)	(143,657.0)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,045,570.7	10,045,570.7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,675,550.8	7,606,938.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,275,757.4	778,529.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,275,757.4	778,529.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,275,757.4	778,529.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,134.3	10,636.6
120	Нийтлэг татварын бус орлого	19,134.3	10,636.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,380,659.1	6,817,771.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,467,787.4	7,362,096.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,467,787.4	7,362,096.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,763,848.7	5,913,087.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,855,445.8	4,068,776.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	484,670.7	516,940.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,914.5	232,014.3
2104	Хангамж, бараа материалын зардал	333,706.7	256,448.5
2105	Норматив зардал	240,549.8	124,396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,667.3	305,200.0
2107	Томилолт, зочны зардал	30,205.6	27,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	355,266.2	312,552.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,422.2	69,059.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,703,938.6	1,449,008.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	207,763.5	244,841.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	213,778.5	253,593.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,778.5	253,593.7
2200	Дотоод эх үүсвэрээр	213,778.5	253,593.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(213,778.5)	(253,593.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	(12.6)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	12.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(6,015.0)	(8,764.7)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,957.4	42,942.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,942.4	34,177.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,828,609,200.00	6,563,022,806.59	265,586,393.41	96.1
УРСГАЛ ЗАРДАЛ	6,828,609,200.00	6,563,022,806.59	265,586,393.41	96.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,429,924,600.00	6,165,532,412.59	264,392,187.41	95.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,208,382,500.00	4,068,776,553.08	139,605,946.92	96.7
Үндсэн цалин	2,704,567,100.00	2,673,076,211.08	31,490,888.92	98.8
Нэмэгдэл	853,824,300.00	821,285,456.51	32,538,843.49	96.2
Унаа хоолны хөнгөлөлт	535,131,700.00	494,533,719.29	40,597,980.71	92.4
Урамшуулал	114,859,400.00	79,881,166.20	34,978,233.80	69.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	533,469,400.00	516,940,565.51	16,528,834.49	96.9
Тэтгэврийн даатгал	366,857,900.00	354,172,961.97	12,684,938.03	96.5
Тэтгэмжийн даатгал	44,176,400.00	43,356,282.58	820,117.42	98.1
ҮОМШӨ-ний даатгал	34,166,800.00	33,566,440.89	600,359.11	98.2
Ажилгүйдлийн даатгал	8,387,800.00	7,950,731.34	437,068.66	94.8
Эрүүл мэндийн даатгал	79,880,500.00	77,894,148.73	1,986,351.27	97.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,001,400.00	232,014,297.15	29,987,102.85	88.6
Гэрэл, цахилгаан	75,881,000.00	61,779,002.45	14,101,997.55	81.4
Түлш, халаалт	76,736,300.00	72,753,546.70	3,982,753.30	94.8
Цэвэр, бохир ус	13,935,800.00	10,222,663.00	3,713,137.00	73.4
Байрны түрээс	95,448,300.00	87,259,085.00	8,189,215.00	91.4
Хангамж, бараа материалын зардал	260,775,600.00	256,448,477.00	4,327,123.00	98.3
Бичиг хэрэг	35,631,500.00	35,628,740.00	2,760.00	100.0
Тээвэр, шатахуун	121,776,600.00	121,766,685.00	9,915.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,958,100.00	47,014,107.00	1,943,993.00	96.0
Ном, хэвлэл	7,739,000.00	7,303,500.00	435,500.00	94.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	40,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,630,400.00	44,695,445.00	1,934,955.00	95.9
Норматив зардал	124,498,600.00	124,395,959.40	102,640.60	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,498,600.00	3,416,959.40	81,640.60	97.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	121,000,000.00	120,979,000.00	21,000.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	453,235,400.00	406,993,752.00	46,241,648.00	89.8
Багаж, техник, хэрэгсэл	112,817,700.00	104,703,700.00	8,114,000.00	92.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	58,390,400.00	57,082,235.00	1,308,165.00	97.8
Урсгал засвар	282,027,300.00	245,207,817.00	36,819,483.00	86.9
Томилолт, зочны зардал	34,780,400.00	27,700,022.00	7,080,378.00	79.6
Дотоод албан томилолт	29,805,800.00	25,848,200.00	3,957,600.00	86.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	4,974,600.00	1,851,822.00	3,122,778.00	37.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	481,798,600.00	464,352,712.19	17,445,887.81	96.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,107,200.00	224,350,100.00	12,757,100.00	94.6

Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,072,600.00	0	1,072,600.00	0.0
Даатгалын үйлчилгээ	15,347,900.00	15,207,330.00	140,570.00	99.1
Тээврийн хэрэгслийн татвар	4,287,700.00	3,812,259.00	475,441.00	88.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,569,500.00	703,500.00	866,000.00	44.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	202,738,600.00	202,170,503.82	568,096.18	99.7
Газрын төлбөр	3,386,000.00	3,304,384.00	81,616.00	97.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,289,100.00	14,804,635.37	1,484,464.63	90.9
Бараа үйлчилгээний бусад зардал	70,982,700.00	67,910,074.26	3,072,625.74	95.7
Бараа үйлчилгээний бусад зардал	54,713,600.00	53,137,633.26	1,575,966.74	97.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,269,100.00	14,772,441.00	1,496,659.00	90.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,684,600.00	397,490,394.00	1194206	99.7
Бусад урсгал шилжүүлэг	398,684,600.00	397,490,394.00	1194206	99.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	128,867,400.00	127,936,234.00	931,166.00	99.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	252,035,200.00	252,035,089.00	111.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,782,000.00	17,519,071.00	262,929.00	98.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,828,609,200.00	6,563,022,806.59	265,586,393.41	96.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,818,609,200.00	6,557,364,591.28	261,244,608.72	96.2
Улсын төсвөөс санхүүжих	6,818,609,200.00	6,557,364,591.28	261,244,608.72	96.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	5,658,215.31	4,341,784.69	56.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	5,658,215.31	4,341,784.69	56.6
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	620	558	62	90.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	0	100.0
Төсвийн байгууллага	8	8	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	306	275	31	89.9
Удирдах ажилтан	2	2	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	212	187	25	88.2
Үйлчлэх ажилтан	92	86	6	93.5
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	306	275	31	89.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	214	189	25	88.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	92	86	6	93.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдлийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, дансны бичилтийг журмын дагуу бүртгэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд ахлах аудитор Б.Энхжин, аудитор Ж.Мөнхтуул нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/457 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн ажил, үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чанартай, шуурхай, хүртээмжтэй, нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх;
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах;
- Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг шат дараатайгаар дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төсөвлөх, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үйл ажиллагаандаа мэдээлэл, технологийн дэвшилтэт техникийг нэвтрүүлэх;
- Хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж, үр дүнд үнэлгээ өгөх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол зохион байгуулж албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;

- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 195 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, сайжруулах шаардлагатай байна.

Гадаадын иргэн, харьяатын газар нь Хяналт шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэстэй бөгөөд нийт 6 орон тоотой. Дотоод аудитын нэгжийн ажиллах журам байхгүй ба байгууллагын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу төв болон орон нутаг дахь газар, хэлтэст хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна. Тайлант онд төлөвлөгөөт 4 шалгалт хийж, илрүүлсэн зөрчилд зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн, харьяатын газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгосон. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,316.6 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцож, 166.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139.7 сая төгрөгөөр буурсан. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материалын данснуудад материаллаг өөрчлөлт гарсан нь нийт хөрөнгийн бууралтад нөлөөлсөн байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 34.2 сая төгрөг болж, өмнөх оноос 8.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	41,737.6	32,849.2	8,888.4
Арилжааны банк дахь харилцах	1,204.8	1,328.5	123.7
Дүн	42,942.4	34,177.7	8,764.7

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 34.2 сая төгрөг нь Төрийн сан банкна дахь харилцах дансанд 32.8 сая төгрөг, Голомт банкна дахь харилцах дансанд 1.3 сая төгрөг тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Худалдан авалтын баримтын бүрдэл дутуу 6.8 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрсөн. /ГИХГ-ын харьяа Хойд бүс дэх газар 6.0 сая, Агаарын замын боомтын газар 0.8 сая/

3.5.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Урьдчилгаа дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	9,225.1	2,480.3	(6,744.8)
Дүн	9,225.1	2,480.3	(6,744.8)

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд даатгалын дараагийн онд ногдох төлбөр бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Даатгалын зардлаас дараагийн онд ногдох төлбөрийг урьдчилж гарсан зардлаар тусгаагүй, зардалд хүлээн зөвшөөрсөн /Агаарын замын боомтын газар 0.2 сая/.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,295.5 сая төгрөг болж, өмнөх оноос 190.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	60,323.5	23,634.6	(36,688.8)
Эм боох материал	60,323.5	23,634.6	(36,688.8)
Хангамжийн материал	1425696.8	1271844	(153,852.8)
Бичиг хэргийн материал	36,641.0	31910.4	(4,730.6)
Аж ахуйн материал	166,535.0	167,573.4	1,038.3
Сэлбэг хэрэгсэл	5,193.1	6,186.6	(993.5)
Түлш, шатах тослох материал	61,460.6	45,161.5	(16,299.1)
Барилгын засварын материал	1455.8	2300.25	844.4
Бусад хангамжийн материал	1,154,411.2	1,018,711.8	(135,699.4)
Дүн	1,486,020.3	1,295,478.6	(190,541.7)

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн дүнд эм боох материал болон бусад хангамжийн материалын бууралт голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд 583.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг төсвийн санхүүжилтээр худалдан авч, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн бүртгэсэн 230.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө нийт 814.8 сая төгрөгөөр бараа материал нэмэгджээ. Бараа материалаас тайлант онд 500.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 198.4 сая төгрөгийн бараа материалыг төв болон орон нутаг дахь газар хоорондоо шилжүүлж, 306.8 сая төгрөгийн бараа материалыг акталж, нийт 1,005.4 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ГИХГ-ын харьяа Хойд бүс дэх газар тайлант онд түлш, халаалтын зардлаас худалдан авсан 4.1 сая төгрөгийн нүүрсийг бараа материалын тооцооны дансаар дамжуулалгүйгээр зардалд шууд бүртгэсэн.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,721.4 сая төгрөг болж, өмнөх оноос 66.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
Биет хөрөнгө	8,103,182.6	8,080,781.5	(22,401.1)
Барилга, байгууламж, орон сууц	6,098,499.7	5,933,989	(164,510.7)
Авто-тээврийн хэрэгсэл	830,119.4	1,075,288.1	245,168.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	932,260.6	777,588.9	(154,671.7)
Тавилга, аж ахуйн эд хогшил	153,250.5	217,046.4	63,796.0
Зам гүүрийн байгууламж	54,955.3	52,978.3	(1977.0)
Бусад үндсэн хөрөнгө	27,797.3	23,890.7	(3,906.6)
Ном	6,299.8	0.0	(6,299.8)
Биет бус хөрөнгө	551,951.7	640,649.8	88,698.00
Программ хангамж	120,634.7	209,332.8	88,698.00
Бусад биет бус хөрөнгө	431,317.0	431,317.0	0.00
Дүн	8,655,134.3	8,721,431.2	66,296.9

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 253.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, ТӨБЗГ-ын 2021 оны 428 дугаар тогтоол, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар орон нутгийн хөрөнгөөр бий болсон 551.4 сая төгрөгийг хөрөнгийг төрийн өмчид нэмж бүртгэсэн байна.

Тайланд онд ТӨБЗГ-ын 2021 оны 698 дугаар тогтоолыг үндэслэн 945.2 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг 303.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож, 718 дугаар тогтоолоор 756.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны А-1/2246 дугаар албан бичгийн дагуу 116.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст харьяа газар хооронд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 419.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг ГИХГ-т 2019 онд шилжүүлснийг 2021 онд ТӨБЗГ-т мэдүүлж, бүртгэх зөвшөөрлийг шийдвэрлүүлсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 7.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст өгөх өглөг	0.0	7,997.1	7,997.1
Урьдчилж орсон орлого	4,094.4	0	4,094.4
Дүн	4,094.4	7,997.1	3,902.7

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд хувь хүмүүст өгөх 0.1 сая төгрөгийн өглөг болон байгууллагад өгөх 1.3 сая төгрөгийг өглөг, барьцаа хөрөнгө 6.6 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

ГИХГ урьдчилж орсон орлого дансанд байгууллагад өгөх өглөг болон барьцаа хөрөнгийн өглөгийг нийт 7.9 сая төгрөгийг данс буруу ангилан бүртгэсэн.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 10,045.6 сая төгрөг болж, өмнөх оноос 143.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо төгрөг/

/ мянган

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,433,292.5	1,433,292.5	0.0
Хуримтлагдсан үр дүн	6,411,363.5	6,267,706.5	(143,657.0)
Өмнөх үеийн үр дүн	6,242,507.8	6,411,363.5	168,855.6
Тайлант үеийн үр дүн	168,855.6	(143,657.0)	(312,512.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,344,571.7	2,344,571.7	0.0
Дүн	10,189,227.7	10,045,570.7	(143,657.0)

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсанд тайлант оны үр дүн 312.5 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,638.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 7,386.6 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 558.0 сая төгрөгөөр бууруулан, 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,828.6 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 6,818.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,817.8 сая төгрөг олгосон байна.

Тайлант онд 5,658.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, Ковид-19 цар тахлаас шалтгаалан хилийн боомтуудын зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосноос зорчигсдын тоо буурч, визийн үйлчилгээний орлого тасарсан байна.

Хүснэгт 7. Үйл ажиллагааны орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	6,818,609.2	6,817,771.5	837.7	99.9
Туслах үйл ажиллагааны орлого	10,000.0	5,658.2	4,341.8	56.6
Нийт дүн	6,828,609.2	6,823,429.7	259,928.2	99.9

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,563.0 сая төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь батлагдсан орон тооноос цөөн ажилтан ажиллаж, цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэл дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

Зарцуулагдаагүй үлдэгдэл 260.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70420	Цагаачлал, гадаад иргэдийн бүртгэл	6,828,609.2	6,563,022.8	320,996.4	96.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,283,599.0	6,025,443.6	258,155.4	95.9
1.2	80220	Холбооны суваг ашигласны хөлс	132,934.9	132,704.8	230.1	99.8
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	398,684.6	397,490.4	1,194.2	99.7
1.4	81522	Гадаад иргэдийг албадан гаргах зардал	13,390.7	7,384.0	6,006.7	55.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний хүрээнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 2 үзүүлэлтийн зорилтот түвшинг 6,563.6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 96.2 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан цагаачлал, гадаад иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх зорилтоос гадаадын иргэнд виз олгох үйлчилгээ зорилтот түвшиндээ хүрээгүй, 31.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 02 дугаар сараас хилийн боомтуудын зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосонтой холбоотой байна.

Хяналтад хамрагдах Монгол Улсад түр болон байнга оршин суух гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээ буюу зөвшөөрөл олголтын тоо 19.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2019 оны "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 473 дугаар тогтоол, 2020 оны "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай" 213 дугаар тогтоол, 2020 оны "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 164,168 дугаар тогтоолоор бүтээн байгуулалтын ажлаар гадаад иргэд, Монгол Улсын харьяатаас гарсан гэр бүлийн иргэдийн ирсэн тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэл дунджаар 75.4 хувьтай байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 20.7 хувиар зөрүүтэй байгаа нь төсвийн тодотголоор хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлаагүй, урсгал зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй зардалд хөрөнгө зарцуулснаас шалтгаалсан байна.

3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд шилэн дансанд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаарх 6,563.0 сая төгрөгийн ажил, гүйлгээний мэдээллийг бүтэн жил, хагас жил, сар бүрээр, мөн тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн тайлбарыг тухай бүр мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, бүрэн оруулж байх албан зөвлөмжийг хүргүүлж байна.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 331.7 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 239.3 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 92.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

Хүснэгт.9 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	1,900.0	4	1,900.0	-	-	100.0
Зөвлөмж	7	22,900.0	7	22,900.0	-	-	100.0
Дүн	11	24,000.0	11	24,000.0	-	-	100.0

/мянган төгрөг/

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 188.4 сая төгрөгийн 21 алдаа, зөрчил илэрснээс, 32.3 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 125.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 28.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 156.1 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 166.3 сая төгрөгийн түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 182.7 сая төгрөгийн 19 алдаа, зөрчил илрүүлснээс 26.6 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 2.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 125.6 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 28.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1.1 Түүврийн байгууллага

Гадаадын иргэн харьяатын газар

Санхүүгийн тайлангийн залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 11.6 сая төгрөгийн дараах 2 алдааг залруулав. Үүнд:

- Байгууллагад өгөх өглөг болон барьцаа хөрөнгөний нийт 7.9 сая төгрөгийн өглөгийг урьдчилж орсон орлогоор тайлагнасан;
- Харилцагч байгууллага болон ажиллагсадтай хийх тооцоог тооцооны дансаар дамжуулаагүй, зардалд шууд тайлагнаж, 3.7 сая төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн.

Албан шаардлага

Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгохгүйгээр 121.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлыг 7 хувааж, шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4."Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5.7 сая төгрөгөөр дутуу тохируулсныг залруулсан.

4.2.2.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

НБББББ -тай холбоотой асуудал

Илрүүлэлт:

НБББББ-т үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан тохиолдолд бүртгэх бүртгэлийг тодорхой тусгаагүйгээс харьяа байгууллагууд үндсэн хөрөнгийн дансанд үлдэгдэл өртгөөр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын НБББББ-т үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан тохиолдолд бүртгэх бүртгэлийг тодорхой тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил**

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	АХГ-2022/18/НА-СТА-ТТЗ	1					1	2	5,658.2	1	5,658.2							1	-
2	Гадаадын иргэн харьяатын газар	АХГ-2022/330/НА-СТА-ТШЗ	1					1	5	146,275.7	2	11,528.6			1	121,738.8			2	13,008.3
3	ГИХГ-ын Баруун бүс дэх газар	ХОА-2022/27/НА-СТА-ТШЗ	1	1					6	15,889.7	2	12,089.7	1	2,000.0					3	1,800.0
4	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	СЭА-2022/259-НА-СТА-ТШЗ	1	1					3	12,357.1									3	12,357.1
5	ГИХГ-ын Өмнөд бүс дэх газар	ӨМА-2022/109/НА-СТА-ТШЗ	1	1					1	3,027.7	1	3,027.7								
6	ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газар	ДГА-2022/33/НА-СТА-ТШЗ	1	1					2	3,900.0					1	3,900.0			1	-
7	ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	АХГ-2022/331/НА-СТА-ТШЗ	1					1	2	1,299.8									2	1,299.8
	Нийт дүн		7	1	0	0	0	3	21	188,408.2	6	32,304.2	1	2,000.0	2	125,638.8	-	-	12	28,465.2

Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	АХГ-2022/18/НА-СТА-ТТЗ	1	6,563,022.8									1	6,563,022.8
2	Гадаадын иргэн харьяатын газар	АХГ-2022/330/НА-СТА-ТШЗ	1	239,335.4					1	239,335.4				
3	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	СЭА-2022/259-НА-СТА-ТШЗ	1										1	
4	ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	АХГ-2022/331/НА-СТА-ТШЗ	1	92,358.8									1	92,358.8
Нийт дүн			4	6,894,717.0					1	239,335.4			3	6,655,381.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 685 / А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/330/НА-СТА-ТЛД3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгохгүйгээр 121,738,852.00 төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлыг 7 хувааж, шууд гэрээ байгуулсан

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд баталсан хязгаарт багтаан худалдан авалтыг хийх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-316.Docx

0001081673



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 684/AD150055

Улаанбаатар хот

АХГ-2022/330/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 5 саяас дээш үнийн дүнтэй орлого, зарлагын 25 гүйлгээний 239,335,380.00 төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-260230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-315.Docx

0001081671

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]

[illegible]